

Тушаалын төсөл

**МОНГОЛ УЛСЫН  
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
САЙДЫН ТУШААЛ**

2018 оны 01 дүгээр сарын  
...ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

**Жишиг үнийн жагсаалт шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Орчны /агаар, ус, хөрс/ чанарын хяналт шинжилгээний ажил үйлчилгээ, мэдээний жишиг үнийн жагсаалт”-ыг 1 дүгээр, “Иргэний нисэхийн үйлчилгээний мэдээний жишиг үнийн жагсаалт”-ыг 2 дугаар, “Тусгай хэрэгцээний урьдчилсан мэдээний жишиг үнийн жагсаалт”-ыг 3 дугаар, “Тусгай хэрэгцээний горимын мэдээний жишиг үнийн жагсаалт”-ыг 4 дүгээр, “Уур амьсгалын үйлчилгээний мэдээний жишиг үнийн жагсаалт”-ыг 5 дугаар, “Цахим технологи хөгжүүлэгч нарт зориулсан цаг уурын мэдээний жишиг үнийн жагсаалт”-ыг 6 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үйлчлэх, тэдгээртэй гэрээ байгуулахдаа энэхүү жишиг үнийг мөрдөж ажиллахыг Цаг уур, орчны шинжилгээний газар, түүний харъяа байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан “Жагсаалт, үнэ батлах тухай” Байгаль орчны сайдын 1998 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 16 дугаар тушаал, “Агаарын чанарын хяналт шинжилгээний ажлын үйлчилгээний хөлс, хураамжийн хэмжээ тогтоох тухай” Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2011 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А-342 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Н.ЦЭРЭНБАТ